



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 17<sup>1</sup> дүгээр зүйлийн 17<sup>1.2</sup> дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Зам, тээврийн сайдын /хуучнаар/ 2012 оны 59 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР  
САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

  
Ө.ЭНХТҮВШИН

1118268062 5919487 СБТ9512

080488



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 09 сарын 23-ны  
өдрийн 4170 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 192


Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 17<sup>1</sup> дүгээр зүйлийн 17<sup>1.2</sup> дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Зам, тээврийн сайдын /хуучнаар/ 2012 оны 59 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР  
САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *Ф. Энхтүвшин* Ө.ЭНХТҮВШИН



Бүртгэлийн дугаар 333  
МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ХУУЛЬ АР ҮНЭН  
Хуулбар өгссөн агуулгын гарчиг үсэг  
2018 оны 09 сарын 12 өдөр



## АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь автотээврийн хэрэгслийн өмчлөх эрх болон ашиглалттай холбоотой бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх ажлын зориулалтаар ашиглаж байгаа болон Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь энэхүү журамд хамаарахгүй.
- 1.3. Дистрибьюторын түр дугаар олгох бүртгэлийг автомашин үйлдвэрлэгчдийн дистрибьютор байгууллагуудын төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, бүртгэлийн бусад төрлүүдийг Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон байгууллага /цаашид бүртгэлийн байгууллага гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.
- 1.4. Автотээврийн хэрэгслийг бүртгэхдээ “Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томъёо, тодорхойлолт” MNS ISO 3833:2010 стандартыг баримтална.

### Хоёр. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх

- 2.1. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгсэл өмчлөх эрх болон ашиглалттай холбоотой бүртгэлийг холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн хөтөлнө.
- 2.2. Автотээврийн хэрэгслийн бүртгэл нь дараах төрөлтэй байна:
  - 2.2.1. шинээр бүртгэх;
  - 2.2.2. өмчлөгчийн бүртгэл;
  - 2.2.3. техникийн өөрчлөлт;
  - 2.2.4. нөхөн олголт;
  - 2.2.5. бүртгэлээс хасах;
  - 2.2.6. түр дугаар олгох.
- 2.3. Бүртгэл хөтлөхдөө дараах дарааллыг баримтална.
  - 2.3.1. бүртгэлийн мэдүүлэг болон энэхүү журамд заасан автотээврийн хэрэгслийн болон өмчлөгчийн холбогдох баримт бичиг/цаашид “баримт бичиг” гэх/-ийн хамт хүлээн авч иж бүрдэл, мэдээллийн үнэн зөв байдлыг хянана.

2.3.2. техникийн үзүүлэлтийг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн мэдээлэлд үндэслэн бүртгэнэ.

2.3.3. автотээврийн хэрэгслийн холбогдох баримт бичиг, мэдээлэл нь бүрэн бус, зөрүүтэй, хуурамчаар үйлдсэн бол бүртгэхээс татгалзан өмчлөгчид мэдэгдэн буцааж өгнө.

2.3.4. бүртгэлийн мэдүүлэг, баримт бичиг шаардлага хангаж байгаа бол мэдээллийн санд үнэн зөв оруулна.

2.3.5. бүртгэлийн мэдүүлэг, баримт бичгийг цаасаар болон цахим архив үүсгэн баяжилт хийж архивт хадгалуулна.

2.4. Автотээврийн хэрэгслийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэхдээ зөвхөн өмчлөгч өөрийн биеэр ирсэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч болон цахим гарын үсгийг үндэслэн бүртгэнэ.

2.5. "Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага" MNS 4410-2:2017 стандартын 4-р бүлэгт заасан улсын дугаарыг дараах автотээврийн хэрэгсэлд олгоно.

2.5.1. Автомашины улсын дугаарыг дараах байдлаар олгоно.

2.5.1.1. автомашины энгийн улсын дугаарыг дипломат байгууллагын, технологийн, эко болон нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаагаас бусад "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандартын 5.8.1, 5.8.2-т заасан зөвшөөрөгдөх үзүүлэлт бүхий автомашинд;

2.5.1.2. дипломат байгууллагын автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын элчин сайдын яам, консулын газар Олон улсын гэрээний тухай хуулийн 3.1.6-д заасан олон улсын байгууллага болон тэдгээрийн дипломат ажилтны хувийн автомашинд;

2.5.1.3. нийтийн тээврийн хэрэгслийн улсын дугаарыг зорчигч тээврийн стандартаар тогтоосон шаардлагуудыг хангаж нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй бүх төрлийн автобус, таксинд;


2.5.1.4. технологийн тээврийн хэрэгслийн улсын дугаарыг "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандартын 5.8.1, 5.8.2-т заасан зөвшөөрөгдөх үзүүлэлтээс дээш үзүүлэлт бүхий ачааны автомашин, чиргүүлд;

2.5.1.5. эко улсын дугаарыг цахилгаан, ус төрөгчөөр ажилладаг болон тэдгээрийн хосолмол эх үүсвэрээр ажилладаг хөдөлгүүр бүхий автомашинд;

2.5.2. механизмын улсын дугаарыг бүх төрлийн дугуйт трактор, өөрөө явагч машин механизмд;

2.5.3. мотоциклын улсын дугаарыг "Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт" MNS ISO 3833:2010 стандартын 3.5-д заасан мотоциклд;

2.5.4. чиргүүлийн улсын дугаарыг "Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт" MNS ISO 3833:2010 стандартын 3.2-т заасан, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандартын 12-т заасан зөвшөөрөгдөх техникийн үзүүлэлт бүхий чиргүүлд тус тус олгоно.



#### 2.5.5. Түр дугаар:

2.5.5.1. транзит дугаарыг тээврийн хэрэгслийн мэдээллийн сангаас хасагдан Монгол Улсын хилээр гарч байгаа автотээврийн хэрэгсэлд олгоно;

2.5.5.2. дистрибьюторын дугаарыг автотээврийн хэрэгсэл худалдаалах албан ёсны дистрибьюторын эрх бүхий байгууллагын худалдан борлуулахаар импортоор оруулж ирсэн шинэ автотээврийн хэрэгсэлд олгоно.

2.6. Анх олгосон улсын дугаарыг дахин өөрчлөхгүй бөгөөд тухайн автотээврийн хэрэгсэл нь ашиглалтаас хасагдсанаас хойш өмчлөгчийн хүсэлтээр 3 сар хүртэл хугацаагаар хадгалж болно. Тухайн хугацаа өнгөрсний дараа уг улсын дугаарыг дахин олгоно. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд бүртгэлийн байгууллагын даргын шийдвэрээр автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг солино.

#### 2.7. Дараах тохиолдолд автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана.

2.7.1. бүртгэлийн мэдүүлэг болон баримт бичиг нь бүрэн бус, мэдээлэл зөрүүтэй, засварласан, хуурамчаар үйлдсэн;

2.7.2. хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлөөгүй;

2.7.3. техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, тэнцээгүй, жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулаагүй;

2.7.4. зохих байгууллагын зөвшөөрөлгүй зориулалтыг өөрчилсөн;

2.7.5. хуулиар эрх олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өмчлөх эрхэд хориглолт, хязгаарлалт хийсэн;

2.7.6. өмчлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр ирээгүй;

2.7.7. улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй.

2.8. Тухайн автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлийг тодорхой тайлбарлан бүртгэлийн мэдүүлэгт тэмдэглэж гарын үсэг, хувийн дугаар бүхий тэмдэг дарж өгнө.

#### Гурав. Бүртгэлийн байгууллага болон бүртгэгчийн эрх, үүрэг


3.1. Бүртгэлийн байгууллага нь энэхүү журмын 2-т заасан бүртгэл хөтлөхийн зэрэгцээ бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, тайлан гаргах, өмчлөгч болон техникийн ашиглалттай холбоотой лавлагаа, мэдээлэл өгөх үйл ажиллагааг хариуцна.

3.2. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийг тухайн бүртгэлийн байгууллагын даргын томилсон бүртгэгч хөтөлнө.

3.3. Бүртгэгч нь автотээврийн болон эрх зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, Иргэний хууль болон хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, автотээврийн салбарын стандартчиллын талаар автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан байна.

3.4. Бүртгэгч нь хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх ба өөрийн хүлээн авч бүртгэсэн бүртгэлийн мэдүүлэг, автотээврийн хэрэгслийн гэрчилгээнд дарж баталгаажуулна.

3.5. Бүртгэгч нь бүртгэлийн мэдүүлэг, баримт бичгийн иж бүрдэл, түүний үнэн зөв байдлыг хянан үзэж энэхүү журмын 2.7-д зааснаас бусад тохиолдолд бүртгэн авах ба



өөрийн гүйцэтгэсэн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хариуцлагыг хуулийн өмнө хүлээнэ.

3.6. Бүртгэгч нь холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд тусгайлан заасан, эсхүл бие даан шийдвэрлэх боломжгүй асуудлыг холбогдох дээд шатны албан тушаалтанд танилцуулан зөвлөмж, чиглэл авна.

### **Дөрөв. Шинээр бүртгэх бүртгэл**

4.1. Шинээр бүртгэх бүртгэлд импортоор оруулж ирсэн болон Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийг мэдээллийн санд анх удаа бүртгэн оруулах үйл ажиллагаа хамаарна.

4.2. Шинээр бүртгэсэн автотээврийн хэрэгсэлд улсын дугаар, автотээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно.

4.3. Автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэхдээ дараах баримт бичгүүдэд үндэслэнэ.

4.3.1. өмчлөгчийн хүсэлт/ хуулийн этгээдийн хувьд албан хүсэлт, нотариатаар баталгаажуулсан улсын бүртгэлийн гэрчилгээ/;

4.3.2. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;

4.3.3. нотариатаар баталгаажуулсан гэрээ, хэлцэл/худалдах, худалдан авах, бэлэглэх, зээлийн гэрээ гэх мэт/;

4.3.4. төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын хувьд, эрх бүхий байгууллагын шийдвэр,

4.3.5. импортоор оруулж ирсэн шинэ автотээврийн хэрэгслийн хувьд үйлдвэрлэгчийн дагалдах баримт бичиг;

4.3.6. ашиглагдаж байгаад импортоор оруулж ирсэн автотээврийн хэрэгслийн тухайн улсын бүртгэлээс хассан тухай эрх бүхий байгууллагын баримт бичиг, экспортын бусад дагалдах баримт бичиг;

4.3.7. гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг;


4.3.8. техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

4.3.9. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт;

4.3.10. тусгай тоноглол суурилагдсан автотээврийн хэрэгслийн хувьд нэмэлт төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан дүгнэлт;

4.3.11. Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийн хувьд тохирлын гэрчилгээ, техникийн паспорт, автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар /VIN code/ олгосон тухай баталгаажуулсан баримт;

4.3.12. дипломат байгууллагуудын хувьд энэхүү журмын 4.3.7-д зааснаас бусад баримт бичиг болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт.



4.4. Монгол Улсад байнга оршин суугаа болон түр оршин суух гадаадын иргэний автотээврийн хэрэгслийг бүртгэхдээ оршин суух үнэмлэх болон холбогдох бусад баримт бичгийг үндэслэн бүртгэнэ.

4.5. Шинээр бүртгэгдсэн автотээврийн хэрэгсэлд “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017” стандартын дагуу улсын дугаар олгоно.

4.6. Өмчлөгч хүсэлтээ гарган “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. MNS4410:2002” стандартын улсын дугаартай автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017” стандартын улсын дугаараар сольж болно.

4.7. “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. MNS4410:2002” стандартын улсын дугаартай автотээврийн хэрэгсэл нь нэг аймгаас нөгөө аймагт, Улаанбаатар хотоос орон нутагт, орон нутгаас Улаанбаатар хотод гэх мэтээр бусдын өмчлөлд шилжих тохиолдолд “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017” стандартын улсын дугаарыг олгоно.

4.8. “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017” стандартын дагуу олгогдсон улсын дугаарыг “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. MNS4410:2002” стандартын улсын дугаараар сольж олгохгүй.

4.9. Автотээврийн хэрэгслийн улсын дугаар нь дээрх 2 стандартын аль нэгийг нь шаардлагыг бүрэн хангасан байна.

#### Тав. Өмчлөгчийн бүртгэл

5.1. Өмчлөгчөөс олгосон эрх, түүний ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн автотээврийн хэрэгслийн өмчлөгчийг бүртгэнэ.

5.2. Автотээврийн хэрэгслийн өмчлөгчийг бүртгэхдээ дараах баримт бичгүүдэд үндэслэнэ.

5.2.1. өмчлөгчийн хүсэлт;

5.2.2. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;

5.2.3. нотариатаар баталгаажуулсан гэрээ, хэлцэл/худалдах, худалдан авах, бэлэглэх, зээлийн гэрээ гэх мэт/;

5.2.4. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ;


5.2.5. жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

5.2.6. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт;

5.2.7. хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлсөн байх;

5.2.8. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлсөн байх;

5.2.9. төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын хувьд, эрх бүхий байгууллагын шийдвэр.



5.3.автотээврийн хэрэгслийг өмчлөгч хуулийн этгээд нь татан буугдсан бол улсын бүртгэлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн өмчлөгчийн бүртгэлийг шинэчилнэ.

5.4.Автотээврийн хэрэгслийн өмчлөгч иргэн нас барсан тохиолдолд өв залгамжлалын гэрчилгээг үндэслэнэ.

5.5.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан бол түүнийг цуцалсан, өмчлөх эрхийг шилжүүлсэн, эсхүл баталгаажуулсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хязгаарлалтыг цуцалж өмчлөгчийг бүртгэн мэдээллийн санд оруулна.


5.6.Автотээврийн хэрэгслийг шинээр өмчлөгчийн иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг үндэслэн өмчлөгчийг бүртгэж мэдээллийн санд оруулна.

### **Зургаа. Техникийн өөрчлөлт**

- 6.1. Техникийн өөрчлөлтөд автотээврийн хэрэгслийн зориулалт, өнгө, хөдөлгүүр, арал, бүхээгийн өөрчлөлтүүд хамаарна.
- 6.2. Тухайн автотээврийн хэрэгслийн зориулалтыг зөвхөн үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр өөрчлөх ба зөвхөн тухайн үйлдвэрлэгчийн эрх бүхий засварын байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.
- 6.3. Техникийн өөрчлөлтийг бүртгэхдээ дараах баримт бичгийг үндэслэн бүртгэнэ:
  - 6.3.1. өмчлөгчийн хүсэлт, бүртгэлийн мэдүүлэг;
  - 6.3.2. техникийн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт;
  - 6.3.3. нийтийн тээврийн үйлчилгээнээс хасагдсан тухай тухайн тээврийн үйлчилгээг зохицуулах эрх бүхий байгууллагын тодорхойлолт;
  - 6.3.4. арал, бүхээг өөрчлөгдсөн бол гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, бусад баримт бичиг;
  - 6.3.5. зориулалт өөрчилсөн бол үйлдвэрлэгчийн дүгнэлт;
  - 6.3.6. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт;
- 6.4. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл үйлчилгээнээс хасагдсан тохиолдолд тухайн дугаарын сери, дугаарыг өөрчлөхгүйгээр автомашины энгийн дугаарыг олгоно.

### **Долоо. Нөхөн олголтын бүртгэл**

- 7.1. Нөхөн олголтын бүртгэлд автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, лац, автотээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгох зэрэг хамаарна.
- 7.2. Нөхөн олголтын бүртгэлийг дараах баримт бичгийг үндэслэн бүртгэнэ:
  - 7.2.1. өмчлөгчийн хүсэлт, бүртгэлийн мэдүүлэг;
  - 7.2.2. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, лацны үнэ төлсөн баримт;





7.2.3. улсын дугаарын тэмдэг, лац, автотээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгосон тухай тэмдэглэгээг мэдээллийн санд бүртгэнэ;

7.2.4. улсын дугаарын тэмдэг, автотээврийн хэрэгслийн гэрчилгээг зарлуулсан баримт,

7.3. Хуучирч муудсан, цаашид ашиглах боломжгүй болсон улсын дугаарын тэмдэг, автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, лацыг өмчлөгчийн хүсэлтээр сольж олгоно.

### **Найм . Бүртгэлээс хасах**

8.1. Энэхүү бүртгэлд ашиглалтаас хасагдаж буй болон Монгол Улсад ашиглагдаж байгаад экспортод гарч буй автотээврийн хэрэгслийн бүртгэл хамаарна.

8.2. Автотээврийн хэрэгслийг дараах баримт бичигт үндэслэн бүртгэлээс хасна.

8.2.1. өмчлөгчийн хүсэлт;

8.2.2. бүртгэлийн мэдүүлэг;

8.2.3. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарын тэмдэг үрэгдүүлсэн бол олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлуулсан тодорхойлолт;

8.2.4. автотээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрт тушаасан бол тухайн үйлдвэрийн тодорхойлолт.

8.3. Бүртгэгч энэхүү журмын 8.2-д заасан бүртгэлийн мэдүүлэг, баримт бичгийг үндэслэн автотээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарын тэмдгийг хураан авч, мэдээллийн санд бүртгэн, тодорхойлолтыг өмчлөгчид олгоно.

### **Ес. Түр дугаар олгох**

9.1. Монгол Улсад бүртгэлтэй автотээврийн хэрэгслийг экспортод гаргах болон Монгол Улсад импортоор орж ирээд улсын дугаар авах хүртэлх хугацаанд түр дугаарыг олгоно.

9.2. Автотээврийн хэрэгсэл импортлогч дистрибьютор байгууллагуудын худалдан борлуулах зорилгоор оруулж ирсэн бүх автотээврийн хэрэгсэлд гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг үндэслэн дистрибьюторын түр дугаарыг олгоно.

9.3. Дистрибьюторын түр дугаараар зөвхөн гаалиас үзэсгэлэн, худалдааны талбай, агуулах, оршин суугаа газартаа хүрэх болон техникийн хяналтын үзлэгт орох, бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, үзэсгэлэн худалдаанд оролцох зэрэгт замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрнө.


9.4. Түр дугаарыг 1 сар хүртэл хугацаагаар олгоно.

9.5. Дистрибьюторын түр дугаар олгоход дистрибьютор байгууллагын албан хүсэлт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн бүртгэнэ.

### **Арав. Мэдээллийн сан бүрдүүлэх болон цахим үйлчилгээ**

10.1. Мэдээллийн сан нь бүртгэлийн эх баримт бичиг бүхий архив, цахим мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглахдаа эрх бүхий байгууллагаас гаргасан төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохицуулсан журам, зааврыг мөрдлөг болгоно.

10.2. Мэдээллийн сан нь Иргэний бүртгэлийн сан, жолоочийн даатгалын сан, техникийн хяналтын үзлэгийн сан, гааль болон татварын мэдээллийн сан, цагдаагийн байгууллагын, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн сан, хөдлөх



хөрөнгийн мэдээллийн сан зэрэг мэдээллийн сантай энэхүү журмын 10.1-т заасан журмын хүрээнд холбогдон харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

10.3. Автотээврийн хэрэгслийн талаар бусад төрийн байгууллагуудаас авах мэдээллүүдийг бүртгэлийн байгууллага нь баримтаар шаардахгүй ба төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох журмын хүрээнд цахим сүлжээгээр дамжуулан мэдээллийг авч архивлана.

10.4. Үйлчлүүлэгч өөрийн тоон гарын үсгийг ашиглан цахимаар үйлчилгээ авах нөхцөлийг бүртгэлийн байгууллагаас бүрдүүлж үйлчилнэ.

10.5. Бүртгэлийн цахим үйлчилгээ авах иргэн аж ахуйн нэгж байгууллага нь “Цахим гарын үсгийн тухай” хуулийн дагуу тоон гарын үсэг хэрэглэх гэрчилгээ авсан байна.

10.6. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн тоон гарын үсгийг ашиглан төрийн нэгдсэн үйлчилгээний порталаар, эсхүл бүртгэлийн байгууллагын цахим системээр дамжуулан цахим үйлчилгээг авна.

10.7. Цахим үйлчилгээ авахдаа энэхүү журамд заасан бүртгэлийн мэдүүлэг, шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг бүрэн хангасан байна.

10.8. Цахимаар үйлчлүүлэгчид автотээврийн хэрэгслийн гэрчилгээг шуудангаар, эсхүл угтах үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчид хүргэн өгч болно.

10.9. Мэдээллийн санд энэхүү журмын хавсралтаар заасан өмчлөгчийн болон техникийн мэдээллийг бүртгэнэ.

10.10. Мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн марк, загвар, хөдөлгүүр, арлын дугаарыг латин үсгээр, бусад мэдээллийг кирилл үсгээр бүртгэнэ.

### **Арван нэг. Улсын дугаарын үйлдвэрлэл**

11.1. Улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэгч /цаашид үйлдвэрлэгч гэх/ нь зохих журмын дагуу авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэнэ.


11.2. Үйлдвэрлэгч нь тусгай зөвшөөрөл олгосон байгууллага болон бүртгэлийн байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж ажиллана.

11.3. Үйлдвэрлэгч нь улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр бүрэн хангагдсан, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан ажлын байранд үйлдвэрлэлийг эрхэлнэ.

11.4. Улсын дугаарыг “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. MNS4410:2002” болон “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017” стандартын 5 дугаар бүлэгт заасан үзүүлэлт шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэнэ.

11.5. Улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэгч нь бүртгэлийн байгууллагатай цахим сүлжээгээр холбогдсон байх ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цахимаар хянах боломжийг бүрдүүлсэн байна.

11.6. Улсын дугаарын тэмдгийг тухайн үйлдвэрлэгч автотээврийн хэрэгсэлд байрлуулан бэхлэх ба бүртгэлийн байгууллага автомашины зөвхөн арын дугаарыг лацдаж мэдээллийн санд бүртгэнэ.



11.7.Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдгийг зөвхөн бүртгэлээс хассан тохиолдолд хураан авна.

### **Арван хоёр. Бусад зүйл**


12.1.Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

12.2.Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг гаргаж автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангана.


12.3.Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг хэвлүүлэх, хадгалах, зарцуулах үйл ажиллагаанд автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

12.4.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- оОо ---




Монгол Улсын Шадар сайр, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2017 оны 198 тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын нэгдүгээр хэвсрэлт



Өмчлөгчийн мэдээлэл

№	Өмчлөгч	Мэдээлэл	
1.	Иргэн	Иргэншил	
2.		Овог	
3.		Нэр	
4.		Регистрийн дугаар	
5.		Хүйс	
6.		Төрсөн огноо	
7.		Оршин суугаа хаяг	
8.		Холбоо барих утас	
9.		Цахим шуудангийн хаяг	
10.	Аж ахуй нэгж, байгууллага	Нэр	
11.		Регистрийн дугаар	
12.		Байгуулагдсан огноо	
13.		Хаяг, байршил	
14.		Цахим шуудангийн хаяг	
15.		Холбоо барих утас	

Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 12-р сартаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын хоёрдугаар хавсралт



Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн маягт

Техникийн тодорхойлолт

Улсын дугаар	
Арлын дугаар	
Марк	
Загвар	
Төрөл	
Үйлдвэрлэсэн он	
Өнгө	

Өөрчилсөн тэмдэглэл

Арлын дугаар	
Бүхээгийн дугаар	
Хөдөлгүүрийн дугаар	
Өнгө	
Зориулалт	
Гэрчилгээ	

Шилжүүлсэн:

Өмчлөгч	Иргэншил		Хамтран өмчлөгч	
	/Эцэг/эх/-ийн нэр/ Байгууллагын нэр			
	Нэр			
	Регистрийн дугаар			
	Хаяг			
	Утас			

Шилжүүлэн авсан:

Өмчлөгч	Иргэншил		Хамтран өмчлөгч	
	/Эцэг/эх/-ийн нэр/ Байгууллагын нэр			
	Нэр			
	Регистрийн дугаар			
	Хаяг			
	Утас			

Шилжүүлсэн:

Өмчлөгчийн гарын үсэг.....

Хамтран өмчлөгчийн гарын үсэг .....


Шилжүүлэн авсан:

Өмчлөгчийн гарын үсэг.....

Хамтран өмчлөгчийн гарын үсэг .....

.....он.....сар.....өдөр


Монгол Улсын Шадар сайд Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 12-дугаар тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын гуравдугаар хавсралт



Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд  
бүртгэгдэх мэдээллүүд


1. Марк
2. Загвар
3. Үйлдвэрлэсэн улс
4. Үйлдвэрлэсэн огноо
5. Импортолсон огноо
6. Арлын дугаар /VIN дугаар/
7. Хөдөлгүүрийн дугаар
8. Өнгө
9. Бүх жин, кг
10. Даац, кг
11. Өөрийн жин, кг
12. Суудлын тоо
13. Хаалганы тоо
14. Оврын хэмжээ, мм, Урт/Өргөн/Өндөр
15. Хүрдний байрлал
  - 15.1. Баруун
  - 15.2. Зүүн
16. Ангилал
  - 16.1. А ангилал
  - 16.2. В ангилал
  - 16.3. С ангилал
  - 16.4. Д ангилал
  - 16.5. Е ангилал
  - 16.6. Механизм
17. Автотээврийн хэрэгслийн төрөл, зориулалт
  - 17.1. Суудлын автомашин /бүхээгийн хэлбэрээр/.
  - 17.2. Автобус

Монгол Улсын Шадар сайд Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 191 дугаараар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын гуравдугаар хавсралт



- 17.2.1. Угсраа автобус
- 17.2.2. Том оврын автобус
- 17.2.3. Дунд оврын автобус
- 17.2.4. Бага оврын автобус
- 17.2.5. Троллейбус
- 17.3. Ачааны автомашин
  - 17.3.1. Энгийн тэвштэй
  - 17.3.2. Эмээлт зүтгүүр
  - 17.3.3. Өөрөө буулгагч
- 17.4. Тусгай зориулалтын автомашин,
  - 17.4.1. нефтийн бүтээгдэхүүний
  - 17.4.2. сүүний
  - 17.4.3. усны
  - 17.4.4. бохирын цооногийн
  - 17.4.5. барилгын зуурмаг тээвэрлэгч
  - 17.4.6. барилгын зуурмаг шахагч
  - 17.4.7. автокран
  - 17.4.8. техникийн түргэн тусламжийн
  - 17.4.9. эмнэлгийн түргэн тусламжийн
  - 17.4.10. гал командын
  - 17.4.11. ахуйн хог хаягдлын
  - 17.4.12. бусад
- 17.5. Чиргүүл
  - 17.5.1. Ачааны автомашины
  - 17.5.2. Торхтой чиргүүл
  - 17.5.3. Суудлын автомашины
  - 17.5.4. Хагас чиргүүл
  - 17.5.5. Аяллын зориулалттай чиргүүл
  - 17.5.6. Хөргүүр, дулаан тохируулагч бүхий чиргүүл

Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ~~2018~~ оны ~~192~~ тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын гуравдугаар хавсралт



17.6. Мотоцикл

- 17.6.1. 2 дугуйтай
- 17.6.2. 3 дугуйтай
- 17.6.3. 4 дугуйтай
- 17.6.4. Ачааны мотоцикл

17.7. Механизм

- 17.7.1. Дугуйт трактор
- 17.7.2. Өөрөө явагч дугуйт механизм

18. Хөдөлгүүрийн төрөл гэдэгт:

- 18.1. Бензин
- 18.2. Дизель
- 18.3. Хий, дизель хосолсон
- 18.4. Цахилгаан-бензин /Хосолсон /гибрид/
- 18.5. Хий
  - 18.5.1. Шингэрүүлсэн нефтийн хий /LPG/
  - 18.5.2. Байгалийн шахсан хий -/CNG/

18.6. Цахилгаан

18.7. Устөрөгчийн


18.8. Хөдөлгүүрийн багтаамж, см<sup>3</sup>

19. Экологийн ангилал

- 19.1. Евро 0
- 19.2. Евро I
- 19.3. Евро II
- 19.4. Евро III
- 19.5. Евро IV
- 19.6. Евро V
- 19.7. Евро VI
- 19.8. Бусад



Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн *М.Б.* оны *12* тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын гуравдугаар хавсралт



20. Хурдны хайрцаг

- 20.1. Механик
- 20.2. Автомат
- 20.3. Хосолсон/хагас автомат/
- 20.4. Бусад

21. Насжилт /тайлангаар гаргах боломжтой байх/


22. Хөтлөгчийн төрөл

- 22.1. Урд хөтлөгчтэй,
- 22.2. Хойд хөтлөгчтэй,
- 22.3. Давхар хөтлөгчтэй,

23. Тэнхлэгийн тоо, /тоогоор/


-----ooOoo-----

Монгол Улсын Шадар сайд Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 198 тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын төрөвд гээр хавсралт



### Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Technical specifications		ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА, Certificate issuing authority
Улсын дугаар Registration plate number	Хөдөлгүүрийн дугаар, Engine number	
Марк, загвар Make, model	Үйлдвэрлэсэн он, Year of manufacture	
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж Category, engine displacement	Импортолсон огноо, Date of importation	Бүртгэлийн ажилтан Registration officer
Бүх жин Gross vehicle weight	Өнгө, Color	Тэмдэг Stamp
Даац, суудлын тоо Loading capacity, number of seats	ӨМЧЛӨГЧИД OWNER'S	Гарын үсэг Signature
Түрө, Төрөл,	Өмчлөгч, Owner	.....Он.....сар.....өдөр .....YYYY.....MM.....DD
Зориулалт Vehicle designation	Хаяг, Address	Тусгай тэмдэглэл additional note
VIN дугаар, VIN number	Хамтран өмчлөгч, Co-owner	
Арлын дугаар, Chassis number	Хамтран өмчлөгчийн хаяг Co-owner address	
Бүхээгийн дугаар, Cabin number		
№ 00000000		

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ TECHNICAL INSPECTION			(MGL) САНАМЖ	МОНГОЛ УЛС MONGOLIA
Он. Сар. Өдөр YYYY.MM.DD	Техникийн байдал Technical status	Гарын үсэг Тэмдэг signature Stamp	АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ ТА:	 <p>CERTIFICAT D'IMMATRICULATION DU VEHICULE</p> <p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</p> <p>CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION</p> <p>(MGL)</p>
			<ul style="list-style-type: none"> <li>❖ Шинээр автотээврийн хэрэгсэл өмчилж авсан бол 72 цагийн дотор;</li> <li>❖ Ашиглалтаас хассан бол 1 сарын дотор;</li> <li>❖ Нэр, хаяг, арлын болон хөдөлгүүрийн дугаар, өнгө өөрчлөгдсөн бол 7 хоногийн дотор тус тус бүртгүүлэх;</li> <li>❖ Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах;</li> <li>❖ Хуульд заасан хугацаанд албан татвараа төлөх;</li> <li>❖ Тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулах үүрэгтэй</li> </ul>	
Засвартай бол хүчингүй Not valid if edited			№ 00000000	

-----0000-----